



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар

1232

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.2.2, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2.2, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 заалт, 40 дүгээр зүйлийн 40.1.6, 40.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчин, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй хавсралтад дурдсан 165 (нэг зуун жаран тав) иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болсон иргэдэд зохих журмын дагуу мэдэгдэж, газар эзэмшүүлэх гэрээг цуцлах, газрын мэдээллийн сангийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ж.Тамир)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525100673